



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 5/38

Хэрлэн сум


Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2, 1.2.2, 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн Орон нутгийн өмчийн газрын дарга Г.Лхагвахатан, Татварын хэлтсийн дарга А.Гантөмөр нарт мөнгөн урамшуулал олгосугай.

2.Батлагдсан төсөвтөө багтааж албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож, мөнгөн урамшуулал олгохыг Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтсийн нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ